



ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2025.09.05

№ 68

Улаанбаатар хот

Олон улсын зах зээлд бонд гаргах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 41.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.6, 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.13.9, 10.13.31 дэх заалт, Сангийн сайдаас 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн "Хариу өгөх тухай" 01/7983 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд 2025 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр танилцуулсан "Олон улсын зах зээлд бонд гаргах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" асуудлыг хэлэлцэн дэмжсүгэй.

2. "Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 58 дугаар тогтоолын 1 дэх заалтын "Олон улсын зах зээлд 50.0 сая ам.долларын ногоон бонд, 50.0 сая ам.долларын арилжааны бонд, нийт 100.0 сая ам.долларын бондыг" гэснийг "Олон улсын зах зээлд 200.0 сая ам.долларын бондыг" гэж өөрчилсүгэй.

3. "Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 58 дугаар тогтоолын хавсралтыг энэ тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Б.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН